

БАТЛАВ

"ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Г.УУГАНБАЯР

2026 оны ... дугаар сарын ...

Д.СҮХБААТАРЫН ТАЛБАЙ ОРЧМЫН ЦЭЦЭГТ БАЙГУУЛАМЖИЙН ТАРИЛТ,
АРЧИЛГААГ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

2026 оны 07 дугаар сарын 08

Улаанбаатар хот

1	Ажлын даалгавар гаргах үндэслэл	Нийслэлийн Засаг даргын 2026 оны “Эрх шилжүүлэх тухай” А/982 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2026 оны А/134 дүгээр тушаал, “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-ын даргын 2026 оны А/88 дугаар тушаал		
2	Байршил	Жанжин Д.Сүхбаатарын талбай		
3	Зориулалт, хүчин чадал	Жанжин Д.Сүхбаатарын талбайд 80,000 ширхэг нэг наст цэцэг тарих, арчлах		
4	Төслийн гүйцэтгэх хугацаа	Захиалаг, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.		
5	Ажлын цар хүрээ, явц	Ажлын зургийн дагуу тарилт, арчилгаа, хамгаалалт, нөхөн тарилт, хураалтын тээвэр аюулгүй байдлыг бүрэн хариуцаж гэрээ дуусахад хүлээлгэн өгнө.		
6	Цэцэгний нэр төрөл	№	Нэр төрөл	Ширхэг
		1	Судалт хун цэцэг	5000
		2	Улаан хун цэцэг	5000
		3	Улбар шар зөгийн үүр цэцэг	5000
		4	Хулгана сүүл цэцэг	5000
		5	Хилэн цэцэг	5000
		6	Холимог төрлийн цэцэг	10000
		7	Цагаан хун цэцэг	5000
		8	Шар зөгийн үүр цэцэг	5000
		9	Ягаан хун цэцэг	5000
		10	Алаг нүдэн цэцэг	5000
		11	Давхар дэлбээт хун	5000
		12	Нил ягаан хун цэцэг	5000
		13	Мандарваа	5000
		14	Олон өнгөт эрвээхэй цэцэг	10000
7	Хийц ажлын зохион байгуулалт	-Үрслэг нь мөчирлөлт сайтай, богино иштэй тээвэрлэлт, шилжүүлэн суулгалт сайн даахаар сайн чанарын шилбэ бүдүүн ил хөрсөнд суулгахаар бэлтгэнэ. -Үрслэг суулгах талбайн ил хөрсийг 20-25 см гүн хагалж чулуу хог ургамлын үндсийг нь түүж цэвэрлээд, багсармал бордоог хольж чийглэн тэгшилсэн байна. -Үрслэгийг цэцгийн онцлог дэлбээ, 10-15 ширхэгийг 1м2 талбайд 50-70 ширхэг байхаар суулгана. - Хөрсийг нягтрахаас сэргийлж 7 хоногт 1 удаа сийрүүлж хог ургамлыг түүх.		

		-Усалгааг үрслэг суулгасны дараа агротехнологийн дагуу өглөө оройн цагаар хийнэ. -Талбайд гаргасан цэцэг арчилгаагүй, хоргодол ихтэй сийрэг хатсан бол захиалагчид нийлүүлэх тоо хэмжээнд хамааралгүй өөрийн зардлаар нөхөн тарилтыг хийнэ. Гадаад байдал: Гадна талын байдал 2-3 цэцгийн дэлбээ ургасан, бусад ишнээс салаалсан салаа бүр бундуй үүссэн. Шалбарч, хугарч гэмтээгүй, шарлаж хорчийж харлаагүй, эрхтэн нь өвчин хортон, хөнөөлт шавьжинд нэрвэгдээгүй үрийн шинжилгээний бичиг хавсаргасан байна. Хэлбэр: Зөв ургалттай, иш бүрээс олон салаа цэцэг гарах чадвартай, нахиа түрсэн ба 2-3 цэцэг гарсан зөв хэлбэртэй байна. Өнгө: Загвар дизайн гаргахад тохиромжтой тод гоёмсог өнгөтэй байна. Тухайлбал: цагаан, улаан, ягаан, нил ягаан, шар, хөх гэх IWOT Үрслэгийн хэмжээ: • Үндсэн цэцгийн дэлбээний тоо 5-12 ширхэг • Цэцгийн шилбэний өндөр 0.5-15 см хүртэл • Дэлбээний диаметр 2-6 см ба түүнээс дээш Үндэс: Өсөлт хөгжилт сайтай бүдүүн иштэй, салаалсан үндэс ихтэй байх ба үндсийг үржил шимтэй шороотой нь хамт авна. Ачилт тээвэрлэлт: Цэцгийн дэлбээ иш, нахиаг хугалж гэмтээхгүй бүрэн бүтэн тээвэрлэнэ. Цэцгийн үрслэгийг зориулалтын бортогонд суулгасан байдлаар нийлүүлэх
8	Онцгой нөхцөл	-Техникийн тодорхойлолтод заасан бараа материалын хүчин чадал тоо хэмжээг хангаж ажиллах. -Цэцэг нь иш богино бүдүүн, үндсэний систем сайн өвчин хортонд өртөөгүй, механик гэмтэлгүй байх. -Үрслэгийг ургаж буй хайрцагтай нь тээвэрлэнэ. -Үрслэгийг өөр саванд савлах шаардлагатай бол сайтар услаад үндэсний шороотой авч, савлах хайрцгандаа чигжүү өрж тавина. -Тээвэрлэсэн суулгацыг мандал хийх талбайд тухайн өдөртөө багтааж суулгана.
9	Эдийн засгийн тооцоо, төсөв	Төсвийг тооцож ирүүлэх.

ХЯНАСАН:

ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ

ДАРГА

Б.НАРАНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:

ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ

АГРОТЕХНИКЧ

Э.БАЯНЗУЛ